

**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2006 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

/25.10.2006-05.12.2006/

1. НИЙГМИЙН САЛБАР**Нийгмийн хамгаалал, хөдөлмөр**

Монгол Улсын Ерөнхий сайдын 2006 оны 97 дугаар захирамжаар “Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсантай холбогдуулан зөвлөлийн хурлыг 2006 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр хуралдууллаа. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан / ХЭДС/- гийн 2006 оны нэмэлт санхүүжилтийн асуудлыг хэлэлцэж, зарим асуудлыг шийдвэрлэв. Тухайлбал, Бизнес инкубаторын төвүүдийн үйл ажиллагаанд 20.0 сая төгрөг, Бизнес инкубаторын шинэ төв байгуулахад 50.0 сая төгрөг, Бизнесийн хөгжлийг дэмжих 2 төв шинээр байгуулахад 40.0 сая төгрөг, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн төвийн үйл ажиллагааг дэмжихэд 20.0 сая төгрөг, барилгын өргөн мэргэжлийн чиглэлээр сурах бичиг, гарын авлага зохиох, хэвлэхэд 250.0 сая төгрөг, жижиг зээл олгоход 560.0 сая төгрөгийг ХЭДС-гаас нэмж зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” асуудлаарх анхан шатны хангайн бүсийн хэлэлцүүлгийг Архангай аймагт, төвийн бүсийн хэлэлцүүлгийг Улаанбаатар хотноо 2006 оны 11 дүгээр 6-10-ны өдрүүдэд зохион байгуулав. Уг хэлэлцүүлэгт Олон улсын хөдөлмөрийн байгууллага /ОУХБ/-ын Банкогийн товчооны мэргэжлийн ур чадварын сургалт хариуцсан мэргэжилтэн, орон нутгийн Ажил олгогч эздийн холбоо /АОЭХ/, Үйлдвэрчний эвлэлийн холбоо /ҮЭХ/-ны гурван талтын төлөөлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын ажилтнууд оролцож, одоогийн хуулийн орчинд шинжилгээ, үнэлгээ хийсний зэрэгцээ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж буй ажлын хэсэгт зориулан зөвлөмж гаргалаа.

УИХ-ын 2006 оны хаврын чуулганаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт”, Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 137, 2003 оны 243 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар батлуулахаар санал авч байна.

ОУХБ-ын Бээжингийн товчоотой хамтран “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх хөтөлбөр /2007-2010/-ийн төслийг боловсруулж, МҮЭХ, МАОЭНХ, ОУХБ-д хүргүүлэн гурван талт уулзалт зохион байгуулж, хэлэлцүүлэв.

“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв. Хуулийн төслийг яамны вэб сайтад байрлуулан олон нийтийн санал авч эхлээд байна.

ХБНГУ-ын Вюрцбургийн Их сургуулийн зөвлөх мэргэжилтнүүд болон “ЭМЖЖ” ХХК-тай хамтран “Шуугианы дүлий, түүнээс хамгаалах, эмчлэх сургалт”-ыг 2006 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр зохион байгуулж, дуу шуугиан ихтэй оёдол, хивс, төмөр зам, цахилгаан станц зэрэг 30 гаруй байгууллагын эмч, инженер техникийн ажилтнуудыг оролцуулж, дуу шуугианаас урьдчилан сэргийлэх талаарх ХБНГУ-ын туршлагыг танилцуулж, зөвлөгөө өгөв.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоон мэдээллийн үзүүлэлтийг ОУХБ-ын аргачлалын дагуу шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг НХХ-ийн сайдын 2006 оны 112 дугаар тушаалаар байгуулан ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, ажилд нь оруулаад байна.

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг НХХ-ийн сайдын зөвлөлийн 2006 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна. Хуулийн төслийг яамны вэб сайтад байрлуулан олон нийтийн санал авч эхлээд байна.

“Хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл боловсруулан яамдын санал авч, Засгийн газрын

хуралдаанд хэлэлцүүлж, УИХ-д өргөн бариад байна. Хуульд өөрчлөлт орсноор 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн бүх эхчүүдэд жирэмсний 5 сартайгаас нь эхлэн 12 сарын хугацаанд сар бүр нөхцөлт мөнгөн тэтгэмж олгодог болох юм. Энэ арга хэмжээнд нийт 13.5 мянган эх хамрагдах ба 2007 оны төсөвт 3.2 тэрбум төгрөг нэмж шаардагдана. Энэхүү хуульд нэмэлт, өөрчлөлт орохтой холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуульд мөн өөрчлөлт оруулах юм.

Нийгмийн даатгалын тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Үндэсний суурь тэтгэврийн даатгалын тухай хуулийн төсөл болон Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2031 он хүртэл баримтлах үндсэн чиглэлийн төслийг тус тус боловсруулж, НХХ-ийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох яамдын санал авахаар хүргүүлээд байна. Хуулийн төслийг УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны гишүүдэд танилцуулах зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын хөтөлбөр”, Өсвөр үе, залуучуудыг дэмжих үндэсний хөтөлбөр”-үүдийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Хөтөлбөрүүд шинэчлэгдэн батлагдсанаар “Төрөөс хүн амын талаар баримтлах бодлогын баримт бичиг”-т тусгагдсан хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжтой боллоо.

Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа “Тогтвортой амьжиргаа” төслийн хэрэгжилтийн явц, байдалтай танилцах зорилгоор Төв аймгийн Эрдэнэ суманд ажиллаж, сумын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй ажилтай танилцлаа. Түүнчлэн “Тогтвортой амьжиргаа” төслийн эхний шат дуусч, дараагийн үе шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төсөл боловсруулж байгаатай холбогдуулан Дэлхийн банкны холбогдох ажилтантай уулзаж, санал солилцлоо.

Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хууль”-ийн төсөл, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-ийн төслүүдийг УИХ-аар хэлэлцэж байгаатай холбогдуулан холбогдох тайлбар, танилцуулга бэлтгэх, Монгол Улсын ерөнхий сайдын 2006 оны 28 дугаар захирамжийн дагуу Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн хэтийн цогц бодлого”-д тусгах хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын урт хугацааны бодлогыг тодорхойлох, Мянганы хөгжлийн 1 болон 3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын 2015 он хүртэлх зорилтууд, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн тооцоог эцэслэн боловсруулах ажилд гол анхаарлаа хандуулан ажиллалаа.

Нийгмийн хамгаалал, ялангуяа нийгмийн халамжийн чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, түүний хэрэгжилтийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг тухай бүр зохион байгуулж ажилласны зэрэгцээ нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудлаар хэвлэл, мэдээллийн ажилтнуудын уулзалтыг тусгайлан зохион байгуулж, мэдээлэл өглөө.

БНСУ-д ажиллах хүч зуучлах асуудлаар хэвлэлийн бага хурлыг Хэвлэлийн хүрээнд зарлан хийлгэж, сэтгүүлчдийн сонирхсон асуултанд хариу өглөө.

Эрүүл мэнд

Монгол улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор эрүүл мэндийн даатгалын санхүүжилттэй холбоотой шийдвэрлэвэл зохих асуудлын талаар санал боловсруулах, тусламж үйлчилгээний зардлыг тооцох аргачлал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2006 оны 108/350 тоот тушаалаар батлав.

Монгол улсын Засгийн газрын 2005 оны 72 тоот тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн салбар /ЭМС/-ын Мастер төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, тус яамны төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор ЭМС-ын мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг зохицуулах албаны бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны “замын зураг” төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2006 оны 351 тоот тушаалаар батлав.

Эрүүл мэндийн сайдын 2006 оны 352, 371 тоот тушаалаар шалгаруулалтын болзол хангасан 36, багц цаг биелүүлсэн 71, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн шалгалтанд тэнцсэн 149, гадаадын 2 эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээ олгов.

Эрүүл мэндийн суурь болон яаралтай тусламжийн хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор 15000 ам.долларын үнэ бүхий багийн бага эмчийн мотоцикл, 68940 ам.долларын үнэ бүхий AMBULANCE H-1 starex маркийн автомашин, 110478 ам.долларын үнэ бүхий эх, нярайн

тусламжийн багаж, тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн сайдын 2006 оны 359 тоот тушаалаар аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нийслэлийн II, III амаржих газруудад хуваарилав.

Нийслэлийн II амаржих газарт нярайн халдварын дэгдэлт гарсантай холбогдуулж эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээг зохицуулах зорилгоор Нийслэлийн II амаржих газрын үйлчлэх хүрээний эх барихын тусламж, үйлчилгээг 11 сарын 13-ны өдрөөс Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн эх барих эмэгтэйчүүдийн клиникт түр хугацаагаар шилжүүлж, яаралтай тусламжийн төвийн үйл ажиллагааг зохицуулав.

Тамхины хяналтын тухай Монгол улсын хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тамхины хэрэглээнээс хүний эрүүл мэндэд учрах хор хөнөөлийн талаар харуулсан “Эрүүл мэндийн зурагтай анхааруулга”-ын загварыг Эрүүл мэндийн сайдын 2006 оны 368 тоот тушаалаар баталж, энэхүү анхааруулгыг тамхин бүтээгдэхүүний стандартад тусган хэрэгжилтийг зохицуулах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран 2007 оны эхний хагаст багтаан авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн бодлого зохицуулалтын газрын даргад даалгав.

□□□ □□□□ □□□□□□□□□□ West Coast Pharmaceuticals □□□□□□□□ □□□□□□□□ □□□□□□□□ □□□□□□ □□□□□□□□ 30□□, □□□-□□ □□□□□ □□□□□□□□ □□□□□□□□□□ 2500□□ □□□□□□□□ 50□□, 360 □□ □□□□□□□□ □□□□ 100□□ □□□□□□□□□□□□, □□□□□□□□□□□□ □□□□□□□□ □□□□□□ □□□□□□ □□□□□□ □□□□□□ □□□□□□.

- 2006 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 39552 эх төржээ. Үүнээс 29 эхийн эндэгдлийн тохиолдол гарсан нь 100 000 амьд төрөлтөд 73,3 болж өмнөх оны мөн үеэс 1,4 дахин буурсан байна.
- Улсын хэмжээнд нялхсын эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхэд тутамд 19,6 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс буурсан байна.
- Улсын хэмжээнд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхэд тутамд 23,8 байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 5 промилээр буурсан боловч нэлээд аймагт тухайлбал Баянхонгор (40,0), Хөвсгөл (36,7), Увс (27,1), Өвөрхангай (25,6), Өмнөговь (26,6), Завхан (24,9) Дорнод (24,3), Ховд (24,1) аймгуудад улсын дунджаас өндөр байна.
- 2006 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд нас баралтын 13076 тохиолдол бүртгэгдсэний 19,6 хувийг осол гэмтлийн шалтгаант нас баралт эзэлж байна.
- 2006 оны эхний 10 сарын байдлаар халдварт өвчний 28997 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн ам тутмаас 112,7 хүн өвчилсөн байна. Нийт бүртгэгдсэн халдварт өвчний 36,6 хувийг бэлгийн замаар дамжих халдвар, 16,3 хувийг вирус гепатит, 14,6 хувийг сүрьеэ, 15,7 хувийг гахай хавдар, 3,6 хувийг салхин цэцгийн өвчлөл эзэлж байна.
- Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гахайн хавдрын өвчлөл 3.1 дахин нэмэгдэж өвчлөл нэлээд өсч 10 000 хүн тутмаас 17,7 хүн өвчилсөн байна. /Өнгөрсөн оны мөн үед 10 000 хүн амд ногдох гахайн хавдар 5,8 байсан/ □□□□□□□□ Өвөрхангай, Булган, Дорнод, Дундговь аймаг Улаанбаатар хотод өвчлөл улсын дунджаас өндөр байна.
- БЗДХ-ын нэг болох тэмбүү өвчний өвчлөл өнгөрсөн оны мөн үеэс нэмэгдэж 10000 хүн амд 9,7 болсон байна. (Өнгөрсөн оны мөн үед 7,4 байсан)
- Мөн энэ оны эхний 10 сард улаанууд өвчин Дорнод, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. **Дорнод аймагт** нийт 169 тохиолдол бүртгэгдсэн нь улс болон аймгийн дунджаас **28,5** дахин өндөр байна.
- Өргөн дархлаажуулалтад хамрагддаг улаан бурхан, сахуу, халдварт саа, хөхүүл ханиад зэрэг халдварт өвчнүүдийн тохиолдол гараагүй.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан

Дээд боловсролын байгууллагад тавих нийтлэг шаардлага, дээд боловсролын диплом олгох журмыг шинэчлэн боловсруулж яамны нэгжийн дарга нарын зөвлөл, сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлээ.

”Гадаадад суралцах оюутныг сонгон шалгаруулах журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны нэгжийн дарга нарын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлээ.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулах “Гаалийн шинэчлэл, модернизаци төслийн зээлийн хэлэлцээр”-ийн төслийн тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, УИХ-ын холбогдох байнгын хороодтой зөвшилцсөний үндсэн дээр зээлийн хэлэлцээр байгуулахыг Сангийн сайдад даалгасан байна. Энэхүү зээлийн хэлэлцээг 2006 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хийж, Азийн хөгжлийн банктай зээлийн гэрээний төслийг тохиролцсон байна. Энэхүү хөтөлбөр нь гаалийн эрхзүйн орчныг бүрдүүлэх, хүний нөөцийн бодлого боловсруулах, ил тод байдлыг сайжруулах, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг хөнгөвчлөх, мэдээллийн технологийг хөгжүүлэх асуудлыг багтаасан байна. Азийн хөгжлийн банк төслийг санхүүжүүлэхэд 5 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 500.0 мянган ам.доллартай тэнцэх буцалтгүй тусламжийг олгох болно.

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг УИХ-ын байнгын хороодын болон нэгдсэн хуралдаанаар хоёр удаа хэлэлцүүлж, улмаар УИХ-ын нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталж, УИХ-ын тогтоол гаргасан байна. Эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд ДНБ-ний өсөлтийг 8.6 хувь, бараа, үйлчилгээний үнийн өсөлтийг 5.0 хувь байхаар тооцож, төсвийн байгууллагын албан хаагчдын цалинг 20 хувиар, өндөр настны тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 69,000 төгрөгт хүргэхээр заасан байна.

Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн төслийг УИХ-ын байнгын хороодын болон нэгдсэн хуралдаанаар гурван удаа хэлэлцүүлж, улмаар УИХ-ын (2006 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн) нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийг эцэслэн баталсан байна. Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн нийт орлогыг **1,293.3** тэрбум төгрөгөөр, улсын төсвийн нийт зарлагыг **1,420.3** тэрбум төгрөгөөр тус тус баталсан байна. Монгол улсын төсвийн 2007 оны урсгал тэнцэл (өссөн дүнгээр)-ийг 96,850.4 сая төгрөгийн ашигтай, нийт тэнцлийг 126,991.8 сая төгрөгийн алдагдалтай байхаар тооцсон байна.

Дэлхийн банк, түүний харьяа байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй 5 төслийн нийт 70 удаагийн төлбөр гүйцэтгэх хүсэлтийг хянан үзэж, нийтдээ 1,5 сая ам.долларын, 18,2 сая төгрөгийн санхүүжилтийн зөвшөөрлийг олгосон байна. Тусламжийн барааны орлого төвлөрүүлэлтийн **2006 оны 11 дүгээр** сарын мэдээг нэгтгэн гаргаж, нийт **119,748.1** мянган төгрөгийн хөрөнгийг тусламжийн санд төвлөрүүллээ.

БНПАУ-ын Засгийн газраас БНМАУ-ын (хуучнаар) Засгийн газарт 1976-1980 онд олгосон шилжих рублийн зээлийн үлдэгдэл, мөн хоёр улсын хоорондын худалдааны устгалын дансны өглөг болох нийт 29,9 сая шилжих рублийн өрийг зохицуулах хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг (2006 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр) байгуулж, гарын үсэг зурсан байна. Хоёр талын Сангийн яамдын шинжээч нарын түвшинд шилжих рублийн өрийн асуудлыг зохицуулах хэлэлцээг тууштай явуулж ирсний дүнд харилцан ашигтай байх хувилбараар өрийг шийдвэрлэх нэгдсэн тохиролцоонд хүрч чадсан байна. *Тухайлбал*, 29,9 сая шилжих рублиэр илэрхийлэгдсэн өрийн үлдэгдлийг америк долларт хөрвүүлэх итгэлцүүрийг 10,44:1 байхаар тохирч, шилжих рублийн өрийн хэмжээг 90,4 хувиар хөнгөлж, нийтдээ 2,87 сая ам. доллартай тэнцэхүйц хэмжээний өрийг зохицуулах тохиролцоонд хүрсэн байна.

Монгол улсын 2007 оны төсвийн төслийг УИХ-ын Байнгын хороодын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх явцад хөрөнгө оруулалтын чиглэлээр гарсан саналд тайлбар өгөх, танилцуулга бэлтгэх ажлыг зохион байгуулж, Монгол улсын 2007 оны төсвийн болон Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх 600 орчим төсөл, арга хэмжээний жагсаалтыг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулав. Монгол улсын төсвийн 2007 оны хөрөнгө оруулалтын хэмжээг **303** тэрбум төгрөг байхаар баталсан нь 2006 оныхоос даруй 2.2 дахин нэмэгдсэн байна.

- Улсын нэгдсэн төсөвт 2006 оны эхний **10 сард** нийт **902,8** тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс **1,064,4** тэрбум төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 17.9 хувиар давуулан биелүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 392,8 тэрбум төгрөгөөр буюу 58,5 хувиар илүү байна. Монгол улсын нэгдсэн төсвийн зарлага **786,2** тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт

зарлагын 85,1 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 205,7 тэрбум төгрөгөөр буюу 35.2 хувиар өссөн байна.

- Хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлээр (өссөн дүнгээр) 100,3 тэрбум төгрөгт хүрч, 63,1 хувийн, түүнчлэн дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт 91,9 тэрбум төгрөгт хүрч, 63,8 хувийн тус тус гүйцэтгэлтэй гарсан. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл бага хувьтай гарахад 2006 оны төсөвт тусгагдсан объектуудын зураг төсөв, техникийн нөхцөл болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагаа удааширч байгаатай холбоотой байна. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг мөн үетэй харьцуулахад 48,2 тэрбум төгрөгийн санхүүжилт илүү хийгдсэн байна.
- Орон нутгийн төсвийн дүнгээр төсвийн орлогын төлөвлөгөө 4,9 хувиар давж, зарлага 99,4 хувиар санхүүжигдсэн байна. Говь-Алтай, Дархан-Уул, Өмнөговь аймгаас бусад аймаг орлогын төлөвлөгөөг биелүүлсэн бөгөөд Завхан, Төв, Сэлэнгэ, Сүхбаатар аймаг төсвийн орлогын төлөвлөгөөг 18,7-179.1 хувиар давуулан биелүүлжээ. Улсын төсөвт орон нутаг нийтдээ 20,5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөө 92.7 хувийн гүйцэтгэлтэй гарахад Булган, Өмнөговь аймаг орлого төвлөрүүлэлтийг зохих хувиар тасалсан явдал голлон нөлөөлжээ. Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл (өссөн дүнгээр) **426,1** тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл **278,2** тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Төсвийн орлого давсан нь эдийн засаг тогтвортой өсч байгаагийн баталгаа юм.
- Улсын хэмжээнд 2006 оны 11 дүгээр сарын 1-ний байдлаар улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын нийт авлага **7.9** тэрбум, нийт өглөг **6.8** тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан дүн мэдээтэй байна.
- Улсын төсвөөс 1110 төсөвт байгууллагын зардалд зориулан 2006 оны эхний 11 сарын байдлаар нийтдээ **506,9** тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. *Тухайлбал*, халамжийн тэтгэвэрт **24,7** тэрбум төгрөг, тэтгэврийн даатгалын санд **55,7** тэрбум төгрөг, тэтгэврийн нөхөн олговорт **707,2** сая төгрөг, хүүхдийн мөнгөний тэтгэмжид **24,8** тэрбум төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмжид **6,0** тэрбум төгрөг, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжид **4,6** тэрбум төгрөг, шинэ гэр бүлийн мөнгөн тусламжид **6,4** тэрбум төгрөг, төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын хураамжид **4,4** тэрбум төгрөг, хэлмэгдэгсдийн нөхөн олговорт **100,0** сая төгрөг, УИХ-д суудалтай намуудын дэмжлэгт **585,0** сая төгрөг, эрчим хүчний алдагдлын зөрүүлж нөхөхөд **6,0** (тухайн сард 600.0 сая төгрөг) тэрбум төгрөг, төсөвт байгууллагын урсгал зардалд **397,6** тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.
- 2006 оны эхний 11 сард Засгийн газрын нөөц сангаас **3,3** тэрбум төгрөг (тухайн сард 486,9 сая төгрөг), улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас **1,8** тэрбум төгрөг (тухайн сард 6.6 сая төгрөг) зарцуулсан байна. Мөн 2006 оны эхний 11 сарын байдлаар орон нутагт олгох НӨАТ-н шилжүүлгээр 15,8 тэрбум төгрөг (тухайн сард 1.1 тэрбум төгрөг), санхүүгийн дэмжлэгээр 7,2 тэрбум төгрөг (тухайн улиралд 0.1 тэрбум төгрөг) хуваарилан олгосон байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2006 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг тухай бүр хянаж, тайлант сард нийт **11.9** төгрөгийн санхүүжилтийн **273** эрхийг нээсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2006 оны эхний 11 сард **79.1** тэрбум төгрөг (тухайн сард **10.9** тэрбум төгрөг)-ийн арга хэмжээг санхүүжүүлсэн байна.
- Засгийн газар 2006 оны эхний 11 сард (өссөн дүнгээр) гадаад зээлийн үндсэн төлбөрт 29,9 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 14,8 тэрбум төгрөг, нийт **44,7** тэрбум төгрөг төлсөн байна. Арилжааны банкуудаас дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 2006 оны эхний 11 сард (өссөн дүнгээр) зээлийн үндсэн төлбөрт 17.2 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 6.9 тэрбум төгрөг, нийт **24.1** тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авсан байна.
- Засгийн газрын бондын үндсэн төлбөрт 3.9 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 374,6 сая төгрөг, бүгд **4.3** тэрбум төгрөг төлсөн байна. Монгол банкны зээлийн үндсэн ба хүүгийн төлбөрт эхний 11 сард 67,9 тэрбум төгрөг (тухайн сард 5,8 тэрбум төгрөг)-ийг төлж барагдуулсан байна. Үүний дүнд 2006 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар Засгийн газрын үнэт цаасны нийт үлдэгдэл 44,9 тэрбум

төгрөг, Монгол банкны зээлийн үлдэгдэл 19,2 сая ам.доллар болтлоо буурсан байна.

- 2006 оны эхний 11 сард нийт 9.0 (тухайн сард 400 сая) тэрбум төгрөгийн 2,767 (тухайн сард 242) тооны амлалтыг бүртгэж, тухайн төсөвт байгууллагын батлагдсан төсвөөс нөөц үүсгэсэн амлалтаас 9,360.5 (тухайн сард 630,1 сая) сая төгрөгийн гүйлгээг бэлтгэн нийлүүлэгч байгууллагад шилжүүлэн санхүүжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Үйлдвэр, худалдаа

“Газар зүйн заалт болон Хөнгөлөлтийн шинэ системийг ашиглан Монголын экспортыг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд 11 сарын 3-ны өдөр “Европын Холбооны Худалдааны Шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий системийн давуу тал, ач холбогдол” сэдэвт сургалт семинар зохион байгуулсан. Мөн Европын Холбооны Худалдааны хөнгөлөлтийн ерөнхий системийн тухай товхимолыг англи, монгол хэл дээр хэвлүүлэв.

Залуу бизнес эрхлэгчдийн анхдугаар зөвлөлгөөнийг Улаанбаатар хотноо 2006 оны 10 дугаар сарын 31-ны өдөр зохион байгуулав.

Ноос ноолуурын холбоо, мөн тус салбарын гол үйлдвэрлэгч болох “Говь”, “Буян”, “Ээрмэл” ХХК-тай, мөн Махны холбоо, архи ундаа экспортоор гаргаж буй аж ахуйн нэгж байгууллагуудтай уулзан Европын Холбооны зах зээл дээр гарахад учирч буй саад бэрхшээл, тэдгээрийг даван туулахад Хөнгөлөлтийн шинэ системийг хэрхэн ашиглах талаар зөвлөлдөн ярилцсан. Түүнчлэн мөн сэдвээр ГХОГ болон МҮХАҮТ зэрэг экспортыг дэмжих холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулав.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг түшиглэн байгуулагдах уулын үйлдвэрүүдэд төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, эзэмшсэн хувь хэмжээнийхээ хөрөнгө оруулалтыг яаж оруулах тухай бодлогын баримт бичиг боловсруулав.

Үйлдвэр, худалдааны салбарыг 2007-2021 онд хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулав.

АНУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын Ерөнхий хэлэлцээрийн хамтарсан зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлын хүрээнд АНУ-ын ЭСЯ, Төрийн Департаментын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж, санал солилцов.

Хөнгөн үйлдвэрийн талаар

“Технологи дамжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн үзэл баримтлалыг батлуулахаар бэлэн болгов.

“Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд санал өгөв.

Жижиг дунд үйлдвэрлэлийг /ЖДҮ/-ийг 2015 он хүртэл хөгжүүлэх Стратегийн баримт бичигт ЖДҮ-ийн талаар нэмэлт оруулав.

Үйлдвэрлэл, Технологийн Паркийн Техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийг Дэлхийн банк болон Олон улсын Санхүүгийн корпорацид тавив.

“Химийн хорт бодис болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалтыг батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан БОЯ-нд хүргүүлэв. “Химийн хорт бодис болон аюултай бодисын зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгөв.

Хөх хотод зохион байгуулагдах БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн газар хоорондын Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны байнгын зөвлөлдөх ажлын хэсгийн 7-р хуралдааны хэлэлцэх асуудалд оруулах саналыг бэлтгэв.

Сайдын өгсөн чиглэлийн дагуу “Ноос, ноолуур боловсруулах цогцолбор”, “Арьс ширний боловсруулах цогцолбор”, “Модны үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулах төсөлд тус тус нэмэлт тооцоо, тодотгол хийв.

ЖДҮ-ийг дэмжих зорилгоор Улсын төсвөөс хуваарилсан 1 тэрбум төгрөгийг банкуудаар дамжуулж олгох талаар хамтран ажиллах гэрээ, сайдын тушаалын төсөл боловсруулж батлуулан, дүүрэг, бүсүүдэд сургалт семинар зохион байгуулав.

Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн талаар

“Эрдэс баялгийн салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ын төслийг УИХ-аар батлуулав.

Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулах тухай УИХ-ын тогтоолын төсөл, стратегийн ордод хамааруулах ордын жагсаалтыг шалгуур үзүүлэлтийн хамт боловсруулж холбогдох яамдаас санал авч Засгийн газрын хуралдаан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэв.

“Ашигт малтмалын тухай хууль” шинээр батлагдан гарсантай холбогдуулан энэ хуулийг дагаж мөрдөх зэрэг 16 журам, зааврыг Үйлдвэр, худалдааны сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох зөвлөмж гарч БНХАУ-ын Чайна Голден Сий Петролиум Эксплорейшн, Канад улсын Шаман Ресорсус компанийн үзэглэсэн гэрээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл /ҮАБЗ/ -өөр хэлэлцүүлэн холбогдох зөвлөмж гаргуулав.

“Улаанбаатар-Мандалговь-Оюутолгойн 220 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын санхүүжилтийн тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл”, Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн эрчим хүчний эх үүсвэр барих тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төслүүдэд санал боловсруулж ТЭХЯ-нд хүргүүлэв.

Газрын тосны хайгуулын 4 талбай дээр гэрээлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа хийгдэж байна.

Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг түшиглэн металлургийн үйлдвэрийн цогцолбор байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтын эдийн засгийн тойм тооцоог боловсруулав.

Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулах арга хэмжээний хүрээнд “Монгол дахь Японы жил” үйл ажиллагаанд геологи, эрдэс баялгийн салбарт хэрэгжсэн, хэрэгжилтийн шатандаа явж байгаа болон цаашид хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулав.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар

Ерөнхийлөгчийн ОХУ-д хийх айлчлалын бэлтгэл ажилд оролцох, Москвагийн тунхаг бичиг болон яриа хэлэлцээний сэдэвт ҮХЯ-ны саналыг бэлтгэж явуулав. Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2010 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн эцсийн хувилбарыг монгол хэл рүү орчуулж Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэв.

БНХАУ-тай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар баримтлах чиглэлийг боловсруулж Бээжин дэх ЭСЯ-нд явуулав.

Ерөнхий сайдын БНХАУ-д хийх айлчлалын бэлтгэлийг хангах, уулзалт ярианы сэдэв, сонинд нийтлэх материал, бизнесийн уулзалтад хийх мэдээллийг бэлтгэх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж айлчлалыг хэрэгжүүлэх ажилд оролцов. БНХАУ-тай хоёр талын түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр байгуулах асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай санамж бичгийн төсөлд санал бэлтгэж явуулав.

АНУ-ын ЭСЯ, ҮХЯ, МҮХАҮТ-ын төлөөлөгчид уулзаж ирэх оны эхээр Улаанбаатарт хийх Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн 3 дугаар хуралдааны бэлтгэл ажлын хүрээнд өмнөх хуралдаанаас хойш хийсэн ажил, хуралдааны бэлтгэлийг хангах талаар санал солилцов. Мөн АНУ-ын ЭСЯ-тай хамтран Стандартын асуудлаар хоёр талын холбогдох байгууллагуудын төлөөлөгчдийг оролцуулсан видео конференц зохион байгуулахад оролцов.

Согтууруулах ундаа импортлох аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар танилцуулга, сайдын тушаалын төсөл бэлтгэж сайдын зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэн шийдвэр гаргуулав.

Тамхи импортлох аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар компаниудын материалыг ажлын хэсэг нэгтгэн дүгнэлт гаргуулав.

3. БАЙГАЛЬ ОРЧИН

Био-аюулгүй байдлын тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, уг хуулийн төсөлтэй холбогдуулан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай

түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн төслийг дэмжиж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр болов.

"Тарвага агнахыг хориглох тухай" Байгаль орчны сайдын 2006 оны 370 дугаар тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж улсын бүртгэлийн 2650 тоот дугаарт бүртгүүлж тарвага агнахыг хориглосон холбогдох аймгуудад 2006 оны тоот албан бичгээр хүргүүлж, Байгаль орчны албад, мөрдөж байна. Тарвага агналтын хориглосон хугацаанд Байгаль орчны яамнаас тарваганы арьс гадаадад гаргадаг явдлыг таслан зогсоох, тарваганы арьсны далд бизнесийг хязгаарлах, хууль бус агналттай тэмцэхтэй холбогдсон урамшууллын системийг хөгжүүлэх, тарваганы нөөцийг хайрлах, хамгаалах чиглэлээр олон нийтэд ойлгуулах, сурталчлах, сум, орон нутгийн байгаль хамгаалагч нарыг унаажуулах, хяналт шалгалтыг тогтмолжуулж сайжруулах чиглэлээр хуулийн болон мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах зэрэг арга хэмжээ авч ажиллахаар аймаг, нийслэлийн Байгаль орчны албадад чиглэл өгөөд байна.

"Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд урамшуулал олгох журам", "Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогоос байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг урамшуулах журам"-ыг тус тус Байгаль орчин, Сангийн сайдын 2006 оны 342/366 тоот хамтарсан тушаалыг батлуулсныг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж улсын бүртгэлийн 2652 тоот дугаарт бүртгүүлж аймаг, нийслэлийн Байгаль орчны албад, Улсын мэргэжлийн хяналтын газар болон холбогдох бусад байгууллагуудад албан бичгээр хүргүүлж мөрдүүлж байна.

"Байгаль хамгаалал ба байгалийн нөөцийн тогтвортой менежмент", "Нийтийн эзэмшлийн байгалийн нөөцийн тогтвортой менежмент" төслүүдтэй хамтран Хэнтий, Төв, Улаанбаатар хотоос нийт 80 хүн оролцуулан "Орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор ойд арчилгаа цэвэрлэгээ хийх нь" сэдэвт үзүүлэх сургалт, семинарыг Төв аймгийн Мөнгөнморьт суманд зохион байгуулж, Ойн санд арчилгаа, цэвэрлэгээ явуулах шаардлага, эрх зүйн хэм, хэмжээний талаар семинар, үзүүлэх сургуульд оролцогчдод танилцуулав. Ойн хайгуул судалгааны төвийн инженерүүд ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх аргыг газар дээр нь биечлэн зааж сургав. Ойг тарьж ургуулах ажилд иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог нэмэгдүүлэхээр "Ойн санд таримал ойг худалдаж авах" журмын төслийг боловсруулж, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, ойжуулалт хийдэг аж ахуйн нэгжийн зарим төлөөлөгчид болон яамны газар, хэлтсээс санал авч сайдын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр бэлэн болгов.

2006 оны ойжуулалт, "Ногоон хэрэм"-ийн ажлын гүйцэтгэлийг дүгнэж үзэхэд 4587 га талбайд ойг нөхөн сэргээх ажил гүйцэтгэсэнээс, 1695.1 га талбайд улсын төсвөөр, 199.7 га талбайд орон нутгийн төсвөөр, 2252.7 га талбайд мод бэлтгэдэг аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр, 439.5 га талбайд Бүгд найрамдах Солонгос улсын тусламжийн хөрөнгөөр хийж, 427.5 га талбайд "Ногоон хэрэм" зурвасын зориулалтаар мод тарьсан дүн гарав. Ойжуулалтын ажлыг Сэлэнгэ аймгийн Ой, ан төв, Бугант групп, "Өргөн Сэлэнгэ" ХХК, "Ойн баясах" ХХК, "Ивсэг ой" ХХК, Булган аймгийн Ойн чуулга ТББ, Завханы "За-Шинэстэй" ХХК, Хөвсгөл аймгийн "Ой хөвч" хоршоо, Улаанбаатар хотын "Ойн ирээдүй" ХХК, "Ойн таксаци" ХХК өөрийн гэсэн мод үржүүлгийн газартай, тарьц, суулгац ургуулж, таримал ойн амьдралтыг 75-98.0 хувьд хүргэж сайн хийсэн бол "Ногоон хэрэм"-ийн ажлыг Монгол Солонгосын Ротари клуб, Ховд аймгийн "Үр жимс" хоршоо, Орхон аймгийн Байгаль орчны албаны дэргэдэх МҮГ, Өмнөговь аймгийн "Өгөөмөр" нөхөрлөл сайн хийсэн байна.

Оны эхний 11 сарын байдлаар 116 толгой идлэг шонхор шувууг Саудын Араб, Кувейт, Катар зэрэг улсад гаргаж, улс, орон нутгийн төсөвт 1205.0 мянган ам.долларын орлого оруулав.

Агаарын чанарын мэргэжлийн алба байгуулсантай холбогдуулан орон нутгаас ирэх байгаль орчны хяналт шинжилгээний шуурхай мэдээг агаарын чанарын албанд шууд авах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилтнуудын компьютерийг VSAT-ын сүлжээнд холбов. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах 4 харуулаас хөтөлбөрт ажлын 94.5 хувь буюу 200 сорьц авч шинжилгээ хийлээ. Шинжилгээний дүнгээр хүхэрлэг хийн дундаж агууламжийн хамгийн их утга 0.050 мг/м^3 –д хүрч Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдол 4 удаа ажиглагдсан бол азотын давхар ислийн дундаж агууламжийн хамгийн их утга 0.090 мг/м^3 -д хүрч, нийт 93 удаагийн ажиглалтаас хотын баруун дөрвөн замын орчимд 23 удаа, 13 дугаар хороололд 12 удаа хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдсан байна.

2006 оны 11 дүгээр сард орон нутгаас гадаргын усны 21 сорьц, Туул голын дагуу 12 сорьц авч Байгаль орчны шинжилгээний төв лабораторт гидрохимийн болон бохирдлын

үзүүлэлтүүдийг тодорхойлов. Туул голын уснаас авсан дээжийн шинжилгээгээр хотоос дээш хэсэгт бохирдолгүй цэвэр байсан ба Алтанбулаг сум хүртэлх хэсэгт хотын төв цэвэрлэх байгууламжийн хаягдал усны нөлөөгөөр хүчилтөрөгчийн горим /Сонгины орчим/ алдагдаж, их бохирдолтой байлаа. Усан дахь аммонийн азотын агууламж Усны чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 5-17 дахин, нитритийн азотын агууламж хүлцэх агууламжаас 1.4-30 дахин, эрдэс фосфорын агууламж 2-6 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 1.8-7 дахин, хялбар исэлдэх органик бодисын агууламж хүлцэх агууламжаас 2-3 дахин тус тус давсан бохирдолтой байна. Харин энэ үед Онги-Сайхан овоо, Завхан –Тайшир, Эг-Хантай, Зүүнтүрүү-Булган, Ховд-Өлгий, Хүнгүй-Ургамал, Идэр-Тосонцэнгэл, Богд-Улиастай, Сэлбэ-Улаанбаатар, Дунд гол-Улаанбаатар орчмоор голын ус цэвэр байлаа.

Үйлдвэрийн хаягдал усны сорьцыг Улаанбаатар хотын 5 цэвэрлэх байгууламжийн орох, гарах цэгээс нийт 10 сорьц авч шинжилгээ хийлээ. Шинжилгээний дүнд Төв цэвэрлэх байгууламж 81 хувь, Нисэхийн цэвэрлэх байгууламж 92 хувь, био үйлдвэрийн цэвэрлэх байгууламж 10 хувь, Био орон сууцны цэвэрлэх байгууламж 30 хувь, Налайхын цэвэрлэх байгууламж 99 хувийн цэвэршилтэй байлаа. Усны ёроолын амьтны сорьцын шинжилгээг хөтөлбөрийн дагуу хийж байна.

Монгол улсын Ерөнхий сайдын 2006 оны 11 дүгээр сарын эхээр БНТУ-д хийсэн айлчлалын хүрээнд “Байгаль орчны салбарт хамтарч ажиллах тухай Монгол улс, БНТУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар БНТУ-ын Байгаль орчин, ойн сайд П.Осман нар гарын үсэг зурав.

БНТУ-ын Байгаль орчин, ойн сайд П.Осман нар Монгол улсын Байгаль орчин, ойн сайд И.Эрдэнэбаатартай хамтран 2006 оны 11 дүгээр сарын 23-нд Байгаль орчны яаман дээр зохион байгуулав.

Чех улсын Прага хотод НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн хүрээнд “Аюултай химийн бодисын хууль бус хил дамжуулан тээвэрлэлт” сэдэвт хуралд оролцон “Монгол дахь химийн бодисын хууль бус хэрэглээ” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв. Хуралд оролцогсад “Аюултай химийн бодис болон аюултай хог хаягдлын хууль бус хил дамжуулан тээвэрлэлтэд хяналт тавих, хориглох, хамтран ажиллах” баримт бичгийн төслийг боловсруулах ажилд тус яамнаас төлөөлөгч оролцлоо.

Кени улсын Найроби хотноо Уур амьсгалын өөрчлөлтийн Конвенцид оролцогч Талуудын 12 дугаар Бага хуралд оролцож уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар олон улсын зарим байгууллага, улс оронтой хамтран ажиллах талаар урьдчилан тохиролцов.

4. БҮС НУТАГ, ХӨДӨӨ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ

“Хот, сумуудад усны тусгай хэрэгсэлүүдийг байгуулах” төслийн хүрээнд 2006.11.15-нд Улаанбаатар хотын 5 цэвэрлэх байгууламжийн орох, гарах цэгээс нийт 10 сорьц авч шинжилгээ хийлээ. Шинжилгээний дүнд Төв цэвэрлэх байгууламж 81 хувь, Нисэхийн цэвэрлэх байгууламж 92 хувь, био үйлдвэрийн цэвэрлэх байгууламж 10 хувь, Био орон сууцны цэвэрлэх байгууламж 30 хувь, Налайхын цэвэрлэх байгууламж 99 хувийн цэвэршилтэй байлаа. Усны ёроолын амьтны сорьцын шинжилгээг хөтөлбөрийн дагуу хийж байна.

Үйлдвэрийн хаягдал усны сорьцыг Улаанбаатар хотын 5 цэвэрлэх байгууламжийн орох, гарах цэгээс нийт 10 сорьц авч шинжилгээ хийлээ. Шинжилгээний дүнд Төв цэвэрлэх байгууламж 81 хувь, Нисэхийн цэвэрлэх байгууламж 92 хувь, био үйлдвэрийн цэвэрлэх байгууламж 10 хувь, Био орон сууцны цэвэрлэх байгууламж 30 хувь, Налайхын цэвэрлэх байгууламж 99 хувийн цэвэршилтэй байлаа. Усны ёроолын амьтны сорьцын шинжилгээг хөтөлбөрийн дагуу хийж байна.

Монгол улсын Ерөнхий сайдын 2006 оны 11 дүгээр сарын эхээр БНТУ-д хийсэн айлчлалын хүрээнд “Байгаль орчны салбарт хамтарч ажиллах тухай Монгол улс, БНТУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар БНТУ-ын Байгаль орчин, ойн сайд П.Осман нар гарын үсэг зурав.

БНТУ-ын Байгаль орчин, ойн сайд П.Осман нар Монгол улсын Байгаль орчин, ойн сайд И.Эрдэнэбаатартай хамтран 2006 оны 11 дүгээр сарын 23-нд Байгаль орчны яаман дээр зохион байгуулав.

Чех улсын Прага хотод НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн хүрээнд “Аюултай химийн бодисын хууль бус хэрэглээ” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв. Хуралд оролцогсад “Аюултай химийн бодис болон аюултай хог хаягдлын хууль бус хил дамжуулан тээвэрлэлтэд хяналт тавих, хориглох, хамтран ажиллах” баримт бичгийн төслийг боловсруулах ажилд тус яамнаас төлөөлөгч оролцлоо.

Кени улсын Найроби хотноо Уур амьсгалын өөрчлөлтийн Конвенцид оролцогч Талуудын 12 дугаар Бага хуралд оролцож уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар олон улсын зарим байгууллага, улс оронтой хамтран ажиллах талаар урьдчилан тохиролцов.

холбогдох хүмүүс, төлөөлөгчидтэй уулзаж, МIP (Олон талт төсөл) төслийг 2007 онд хэрэгжүүлж эхлэхээр боллоо.

“Бүс нутгийн авто зам хөгжүүлэх” төслийн А багц БНСУ-ын зээлээр хэрэгжих Чойр-Сайншанд чиглэлийн авто замын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийн асуудлаар EXIM банкны I дүгээр газрын орлогч даргатай уулзалт зохион байгуулан уулзалтаар хэлэлцсэн асуудлаар саналаа бичгээр мэдэгдэн хариуг аваад байна. Үнэлгээний хороо дүгнэлтээ гарган төсвийн ерөнхий менежерт хүргүүлээд байна.

“Бүс нутгийн авто зам хөгжүүлэх” төслийн Чойр-Сайншанд-Замын Үүд чиглэлд тавих замын Б1, Б2 багцын асуудлаар Азийн хөгжлийн банкны төлөөлөгчтэй уулзалт зохион байгуулан санамж бичигт гарын үсэг зурлаа. Б2 багцыг 2 хэсэг болгон хуваах саналыг Сангийн яаманд тавиад байна.

Швед Улсын СИДА байгууллагын Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих “Авто замын засвар арчлалтын менежемент” төслийн зөвлөх компанийн техникийн үнэлгээний тайланг боловсруулав.

Монгол Улсын Их Хурлын даргын 158 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан “Монгол Улсын авто замын сүлжээний өнөөгийн хүрсэн түвшинд үнэлэлт дүгнэлт өгч, улсын чанартай авто замаас ойрын 10 жилд барьж сайжруулах замын чиглэл, уртыг тодорхойлж, шаардагдах хөрөнгө, авах арга хэмжээний хөтөлбөр” боловсрууллаа. Ажлын хэсгийн боловсруулсан хөтөлбөрийн үр дүнгээр 2007 онд авто замын салбарт төлөвлөгдсөн хөрөнгө нь дээр 26,0 тэрбум төгрөг нэмэгдэхээр болов.

Аялал жуулчлалын салбарын дунд хугацааны стратеги /2007-2012/ төлөвлөгөөг Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах уралдаанд түрүүлсэн Соёмбо-21 багийн гишүүдтэй хамтран боловсруулж, аялал жуулчлалын төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, их дээд сургууль, аялал жуулчлалын байгууллагын төлөөлөгчдийг оролцуулан 3 удаа хэлэлцүүлж, батлуулахад бэлэн болгоод байна.

БНМАУ/хуучин нэрээр/-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын “Автотээврийн хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх асуудлаар 2006 оны 10 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд ӨМӨЗО-ны Хөх хотод болсон ээлжит уулзалтын үеэр Хятадын талаас тавьсан Зүүн хатавч боомтоос Сүхбаатар аймгийн Баруун урт хот, Ганц мод боомтоос Таван толгой нүүрсний уурхай, Ганц мод боомтоос Оюу-толгойн орд, Сэхээ боомтоос Нарийн сухайтын нүүрсний уурхай хүртэл ачаа тээврийн шугам нээх, Ганц мод боомтоос Гашуун сухайтын боомтын хооронд зорчигч тээвэрлэлтийн шугам нээх саналыг судлан үзээд Монголын тээврийн хэрэгслийг Хятадын хилийн боомтоос дотогш нэвтрүүлэхгүй байгаа нь Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээрийн ижил тэнцүү байх зарчим зөрчигдөж байгаа тул уг саналыг одоогоор хүлээн авах боломжгүй болохыг ӨМӨЗО-ны Зам харилцааны танхимд мэдэгдэв.

Өмнеговь аймгийн Гашуунсухайт, Шивээхүрэнгийн боомтуудаар тээвэрлэлт гүйцэтгэж байгаа авто замын маршрутын даац нь хүнд даацын автомашин зорчих шаардлага хангасан эсэхийг албан ёсоор Авто замын хяналт, судалгааны төвөөр тодорхойлуулан уг замын даац нь энэхүү шаардлагыг хангаагүй бол шаардлага хангасан авто замыг холбогдох байгууллагууд нь барьж байгуултал эдгээр боомтоор хүнд даацын автомашинаар тээвэрлэлт гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын тээврийн гэрээг түдгэлзүүлэн зогсоох арга хэмжээ авч, хэрэв шаардлага биелүүлээгүй тохиолдолд тээвэрлэлтийн зөвшөөрлийг цуцлах саналыг тус яаманд ирүүлэхийг Тээврийн үйлчилгээний төвд мэдэгдэв.

Тээврийн хэрэгслийн үзлэг, оношлогооны ажлыг эрчимжүүлэх талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээг авч ажилласны дүнд 2006 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн мэдээгээр улсын хэмжээнд оны эхнээс нийт 143258 тээврийн хэрэгсэл техникийн хяналт, оношлогоонд орсон нь хамрагдвал зохих 162620 тээврийн хэрэгслийн 88.9 хувь нь болж байгаа ба үүнээс Улаанбаатар хотод 66873 буюу 87.8 хувь, орон нутагт 76385 буюу 88.3 хувьтай байна.

Засгийн газрын 2005 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай авч хэлэлцээд уг хуралдааны 52 дугаар тэмдэглэлийн 2-ын а-д Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэгдсэн 19 автобус болон сэлбэгийн үнэ 1006.4 сая төгрөгийг тусламжийн орлогын санд төвлөрүүлэхээс чөлөөлүүлэх асуудлыг Японы талтай зөвшилцөн 2006 онд багтаан шийдвэрлүүлэхээр заасаны дагуу Япон Улсын холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч өгөхийг Сангийн яаманд хүргүүлсэн. Үүний дагуу Сангийн сайд Н.Баяртсайхан Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хүсэлтийг албан ёсоор тавьсан бөгөөд Японы талаас дээрх асуудлыг судалж үзэхээ

Мал өвөлжилтийн бэлтгэлийг хангах, өвөлжилтийг зохион байгуулах асуудлаар хийсэн видео хурал дээр аймаг орон нутгаас тавьсан санал хүсэлтийг шийдвэрлүүлж хариу өгөх арга хэмжээ авч байна. Отрын бэлчээр зохицуулалтын талаар хүсэлт ирүүлсэн Сүхбаатар, Хэнтий, Төв аймгийн Засаг дарга нарт хариуг албан тоотоор хүргүүлэв. Бэлчээр усжуулалтын ажлын хүрээнд шинээр 12 аймгийн 14 суманд 14 худаг гаргуулахаар шийдвэрлүүлсэн.

Сүхбаатар, Хэнтий, Сэлэнгэ, Өмнөговь, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Булган, Архангай, Увс аймгуудын худгийн засвар, шинэ худаг барьж байгуулах ажлын гэрээний гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийн эрхийг нээлгэв. Нийт 270 худгийн гидрогеологийн болон техникийн талаарх мэдээллийг нэгтгэв.

БНХАУ-ын Засгийн газрын тусламжаар орж ирж байгаа 20.0 сая юаны техникийг гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлүүлэх арга хэмжээ авч, эхний ээлжинд анжис, борной, хадуур тармуур хүлээн аваад байна.

“КР-2” төслийн хуримтлалын сангийн хөрөнгөөр нийлүүлэгдэх 59 иж бүрдэл бага оврын трактороос 25 ширхэгийг оруулж ирэн угсрах ажиллагаа хийгдэж байна.

Мал эмнэлгийн дуудлага оношлогоо, үйлчилгээний тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хувцас, лабораторийн шинжилгээний халдвартай материал, сэг зэм, мал эмнэлгийн хог хаягдал шатааж устгах төхөөрөмж худалдан авах тендерт үнэлгээ хийж, шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулав.

“Биокомбинат” ТӨҮГ-аас гэрээгээр нийлүүлбэл зохих хуурай болон шингэн вакцин, биобүтээгдэхүүнийг хүлээн авч орон нутагт хүргүүлэв.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 21848.1 мянган мал хамрагдахаас одоогоор 20700.5 мянган мал хамрагдаад байна.

Гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх тарилгад Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Улаанбаатар, Хэнтий аймгуудын 66 сумын 4660.4 мянган мал хамрагдахаас 4735.9 мянган малыг вакцинжуулав.

Паразиттах өвчнөөс сэргийлэх арга хэмжээ туулгалт, боловсруулалтанд 7391.0 мянган мал хамрагдахаас давхардсан тоогоор 7095.0 мянган мал хамрагдаад байна.

Засгийн газрын 2006 оны 178 дугаар тогтоолын дагуу Нийслэл, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн хүн амын 2007 оны хаврын хэрэгцээнд зориулан мах бэлтгэх ажлыг эрчимжүүлэх ажлын явцтай танилцав. Үүнд:

Дархан-Уул аймгийн Засаг даргын захирамжаар “Мах бэлтгэх аж ахуйн нэгжийг сонгох, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулж 2007 оны хаврын хэрэгцээнд зориулан 300.0 тн мах бэлтгэж нөөцлөн үхрийн махыг 2100, хонины махыг 1950 төгрөгөөр борлуулахаар “Дархан мах экспо” ХК саналаа ирүүлсэн байна.

Орхон аймгийн Засаг даргын захирамжаар мөн ажлын хэсэг байгуулсан. Тус аймгийн төвийн хэрэгцээнд зориулан мах бэлтгэж борлуулахаар 3 аж ахуйн нэгж нийт 900.0 тн мах бэлтгэхээр саналаа ирүүлснийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцээд “Эрдэнэт прогресс”, “Монгема” ХХК-иуд тус бүр 150тн /нийт 300.0тн/ мах бэлтгэн, аймгийн хүнсний захуудаар аж ахуйн нэгжүүд өөрийн хүчээр борлуулахаар тохироод байна. Ажлын хэсгийн хурлаар 140 тн үхрийн, 110.0 тн хонины, мөн Орхон аймгийн зах зээл дээр эрэлт, хэрэгцээ ихтэй байдгийг харгалзан 50тн ямааны мах, нийт 300.0 тн мах бэлтгэх, 1 кг үхрийн махыг 1950.0 төг, хонины махыг 1860.0, ямааны махыг 1600.0 төгрөгөөр борлуулахаар тохирсон байна.

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх ажлын хэсэг 10 аж ахуйн нэгжийн санал, хүсэлтийг хүлээн авч үйлдвэр, аж ахуйн нэгжүүд дээр газар дээр нь үзэж танилцсан байна. Ажлын хэсгийн хурлыг 3 удаа хийж, санал ирүүлсэн 10 аж ахуйн нэгжүүдээр нийт 3300.0 тн мах бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн байна.

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн баримт бичгийг эцэслэн боловсруулж, төсөл хэрэгжүүлэх баримт бичигт энэ оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Азийн хөгжлийн банкны суурин төлөөлөгч, Сангийн сайд, ХХАА-н сайд нар гарын үсэг зурав.

5. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАДААД БОДЛОГО

Батлан хамгаалах

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд уг хөтөлбөрийн талаар Батлан хамгаалах яам /БХЯ/, Зэвсэгт хүчний жанжин штаб /ЗХЖШ/-ын удирдлагыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулан, төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж байна.

АНУ-ын Аляска муж улсын Үндэсний Гвардын дарга, хошууч генерал Кемпелл ажлын айлчлал хийж, Төрийн нарийн бичгийн даргатай албан уулзалт хийлээ.

ОХУ-ын БХЯ-ны цэргийн сургалтын байгууллагатай Монголын цэргийн албан хаагчдын сургалтын асуудлаар хэлэлцээ хийх ажлын хэсэг байгуулж Оросын БХЯ-ны төлөөлөгчдийг хүлээн авах бэлтгэл хангаж 2006 оны 11 дүгээр сарын 1-7-ны өдрүүдэд хүлээн авах ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын Зэвсэгт хүчний Энхийг сахиулахын хүчин чадлыг нэмэгдүүлэх EPIC хөтөлбөр, АНУ, Монгол Улсын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоход дэмжлэг үзүүлэх 1,0 сая ам. долларын тусламжийг 2006 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд хүлээн авах ажлыг зохион байгууллаа.

ЗХЖШ-ын даргын баталсан удирдамжийг үндэслэн Зэвсэгт хүчний нийт анги, байгууллагуудын бэлэн байдлын төлөвлөгөөний хэрэгжилт, байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх бэлэн байдлын бэлтгэлжилтийг “Зэвсэгт хүчний анги, салбаруудын байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийн түвшинг шалгаж үнэлэх заавар”-ын дагуу шалган тусалж, илэрэн дутагдлыг газар дээр нь засуулж, дүнг нотломжоор гарган цаашид авах арга хэмжээг тодрхойллоо.

Зэвсэгт хүчний 016, 123, 167, 186, 256, 336 дугаар ангиудын хөдөлгөөнт удирдлагын байруудыг дэлгүүлж, байлдааны салбарууд болон тусгай үүрэг гүйцэтгэх томилгоот бүлгүүдийг ЗХЖШ-ын даргын захирамжаар тодорхой районд гаргаж, цагийн байдал өгч, үүрэг гүйцэтгүүлэн байлдааны буудлага хийлгэх журмаар тэдний байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх бэлэн байдлын бэлтгэлжилтийг шалгалаа.

2007 онд дайчилгааны бэлтгэл нөөцийн I зэргийн үүрэгтэнтэй явуулах сургалтын төсвийн төсөл, Зэвсэгт хүчинд тайван цагт алба хаах цэргийн албан хаагчдын тооны дээд хязгаарыг тогтоох саналыг тус тус боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2006 оны 304 дүгээр зарлигаар батлагдсан “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг боловсрууллаа.

Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн тайван цагийн орон тоонд өөрчлөлт хийж, “Радио холбооны төв”-ийг “Холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангах төв”-тэй нэгтгэх арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Зэвсэгт хүчний анги, байгууллагын жижүүрүүдэд зарлан мэдээллийн дадлагын дохиог 2 удаа өгч зарлан мэдээллийн сувгийн бэлэн байдлыг шалгаж, холбогдох арга хэмжээг авч үүрэгжүүллээ.

Байлдааны жижүүрлэлтийн анги, салбаруудын хүч хэрэгслээр энэ сард 3656 агаарын хөлгийн нислэгт радиолокацийн станцын болон диспетчерийн хяналт тавьснаас 3515 нь олон улсын, 139 нь орон нутгийн, 4 нь тусгай үүргийн нислэг байв. Нислэгийн горим, маршрутын зөрчил илрээгүй.

2006 оны II ээлжийн цэрэг татах, халах ажиллагааг 11 дугаар сарын 1-ээс 10-ны өдрүүдэд осол, авааргүй амжилттай зохион байгуулав. Энэ удаагийн цэрэг татлагаар Ерөнхий зориулалтын цэрэгт 1320 хүнийг татаж хяналтын тоог 97.3 хувиар, гэрээт цэргийн албанд 51 хүнийг элсүүлэн авч хяналтын тоог 54,4 хувиар тус тус биелүүллээ.

“Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн YII ээлжийн бүрэлдэхүүн Олон үндэстний дивиз /төв-өмнөд/-ийн штаб байрлах Ад Дивинях хот дахь “Эко” баазын аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын үүргээ амжилттай биелүүлж байна. Бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, сэтгэл санааны байдал, ахуй хангалт хэвийн байна.

Сиерра Леон Улсад зохион байгуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цэргийн багийнхан тус улсын Фрийтаун хот дахь НҮБ-ын Нарлаг баазад байрлан уг бааз болон Тусгай шүүх дээр 2 хуваагдан үүрэг гүйцэтгэж байна. Бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, сэтгэл санааны байдал сайн, цаашид үүрэг гүйцэтгэх бүрэн боломжтой байна.

Косово дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох Монгол Улсын цэргийн багийн бүрэлдэхүүн Бельги Улсын Леопольдсбург мужийн Беверло цэргийн баазад байрлан ажиллагааны өмнөх сургалтад хамрагдаж байна.

Баруун Сахар, Конго, Судан, Этиоп, Эритрид НҮБ-ын явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд Зэвсэгт хүчний 12 офицер цэргийн ажиглагчаар үүргээ хэвийн гүйцэтгэж байна.

Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн сургалт, өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж, ангиудын бэлэн байдал зохих түвшинд байж, төр засгаас өгөгдсөн байлдааны болон тусгай үүргийг биелүүлэхэд бэлэн байна.

Гадаад бодлого

Энэ 10 дугаар сарын 29-нөөс 11 дүгээр сарын 1-нд Катарын Доха хотноо Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын /АШСТО/-ын 6 дугаар бага хуралд Гадаад хэргийн сайд тэргүүтэй төлөөлөгчид оролцож, АШСТО-ын олон улсын 5 дугаар бага хурлын даргын хувьд үг хэлэв. Түүнчлэн сайд Н.Энхболд АШСТО-ын 6 дугаар бага хурал дээр манай улсаас 5 дугаар бага хурлын мөрөөр хэрэгжүүлсэн бодит ажлууд ардчилсан ололт амжилт, сорилт бэрхшээлүүдийн талаар дэлгэрэнгүй илтгэл тавив. Бага хурлын үеэр Гадаад хэргийн сайд Н.Энхболд Катар улсад ажлын айлчлал хийж, Катарын Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч бөгөөд Гадаад хэргийн сайдтай уулзаж, Катарын Эмирт бараалхаж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцов.

Гадаад хэргийн сайд Н.Энхболдын урилгаар БНКаЗУ-ын Гадаад хэргийн сайд К.Токаев 11 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, хоёр талын улс төр, эдийн засгийн өргөн хүрээтэй асуудлаар түүний дотор өрийн асуудлаар санал солилцов. К.Токаев Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарт бараалхав.

Монгол Улс НҮБ-д элссэний 45 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлыг 10 дугаар сарын 24-нд НҮБ-ыг дэмжигчдийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулав. Бага хурлын нээлтийн ажиллагаанд Гадаад хэргийн дэд сайд Ц.Цолмон оролцож үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын ОХУ-д хийхээр төлөвлөж буй айлчлалын үеэр байгуулах, хүчин төгөлдөр болгох чиглэлээр ажиллаж буй гэрээ, хэлэлцээрүүдийн явцын талаар холбогдох яамд, байгууллагатай хамтран ажиллав. Энэхүү айлчлалын үеэр байгуулах Монгол Улс, Оросын Холбооны Улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээний төслийг Засгийн газрын 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Мөн айлчлалын дүнгээр гаргах Хамтарсан Тунхаглалын төслийг боловсруулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын БНТУ-д хийсэн айлчлалын үеэр байгуулсан Монгол Улсын БОЯ, БНТУ-ын Хүрээлэн буй орчны яам хоорондын Байгаль орчны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын “Монгол нутаг дахь Түрэгийн хөшөө, дурсгал төсөл”-ийн хүрээнд “2006 онд Орхоны хөндийд хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухай хамтын ажиллагааны гэрээ”-ний төслийн орчуулгыг хянаж, гарын үсэг зурав.

Монгол Улсын Ерөнхий сайдын БНХАУ-д хийх айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд Биеийн тамир спортын ордон барих, 2000 тонн улаан буудай нийлүүлэх, бэлчээрийн экологийн судалгааны төвийн төслийн талаар солилцох захидлын төслийг бэлтгэж Сангийн яаманд хүргүүлэв. Ерөнхий сайдын БНХАУ-д хийх албан ёсны айлчлалын үеэр байгуулах баримт бичгүүдийн тухай танилцуулга бэлтгэж ҮАБЗ-ийн 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэв.

Монгол-Хятадын консулын зөвлөлдөх уулзалтын хүрээнд Хятадтай ялтан шилжүүлэх гэрээ байгуулах, хүний болон хар тамхины наймаатай, түүнчлэн хууль бусаар хөдөлмөр эрхлэхтэй тэмцэх талаар хамтран ажиллах, Хятадад Монголын консулын төлөөллийг бэхжүүлэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах болон иргэд харилцан зорчих, хил нэвтрэхтэй холбоотой зарим асуудлыг зохицуулахаар тохиролцов. Энэ үеэр БНХАУ-д суугаа Монголын консулуудын ажлын зөвлөлтөөн хийв.

Монгол-Оросын консулын зөвлөлдөх уулзалтын хүрээнд ОХУ-тай хэтдээ визгүй зорчдог болох үүднээс визийн журмыг хөнгөвчлөх талаар голлон ярилцаж Иргэд зорчих нөхцлийн тухай 1995 оны хэлэлцээрийн 5 дугаар зүйлд заасан визгүй зорчих нотлох баримт бичигтэй болох, визийн хураамжийн тарифыг нэг мөр болгохоор тохиролцов. Манай тал шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, биеийн тамир, спортын улсын байгууллагад ажиллагсад, мөн ОХУ-д хувиараа сурч буй аспирант, докторант, магистрант болон дадлагажигч нарт визийг хураамжгүй олгох, хоёр улсын бизнесменүүдэд нэг жилийн олон удаагийн виз олгох санал тавьсан бөгөөд оросын тал энэ асуудлаар тусгай хэлэлцээр байгуулах шаардлагатай гэж үзэв. ОХУ-д 30 хүртэлх хоногоор зорчих монгол иргэдийг паспортын бүртгэлд хамруулахгүй байх манай саналыг оросын тал холбогдох байгууллагууддаа уламжлахаа амлав. Ханх-Мондын хилийн боомтыг олон улсын зорчигч тээврийн боомт болгох талаарх яриа хэлэлцээг үргэлжлүүлэхээр болов. Мөн иргэдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой зарим асуудлыг хэлэлцэв. Энэ үеэр ОХУ-д суугаа Монголын консулуудын ажлын зөвлөлтөөн хийв.

Монгол-Казахстаны консулын зөвлөлдөх уулзалтын хүрээнд Казахстантай хоёрдмол харъяаллын асуудлыг зохицуулах үүднээс Казахстаны иргэн болсон монгол иргэдийн жагсаалтыг Монголын талд өгч цаашид ийм тохиолдол гаргахгүй байх, Алматыд Монголын консулын төлөөллийг хадгалж үлдээхэд дэмжлэг үзүүлэх, засгийн газар хоорондын гэрээний

дагуу сурч буй оюутнуудад олон удаагийн визийг хураамжгүй олгохоор тохиролцож, Казахстанд 6 монгол иргэний амь насыг бүрэлгэсэн гэмт хэргийг илрүүлэх, Монголд гэмт хэрэг үйлдээд Казахстанд оргон гарсан 9 хүнийг холбогдох гэрээний дагуу шилжүүлэн өгөхөд дэмжлэг үзүүлэхийг казахстаны талаас хүсэв.

Монгол, ОХУ, БНКаЗУ-ын гурван талын уулзалт хийж Казахстанд байнга оршин суугаа Монголын иргэдийг тэнд байнга оршин суугааг нь нотлох баримт бичгийг үндэслэн ОХУ-ын нутаг дэвсгэрээр визгүй дамжин өнгөрүүлж байх, Казахстаны иргэн болохоор Монголын харъяатаас гарсан хүмүүсийг Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албанаас олгосон зорчих баримт бичгийг үндэслэн Монголоос Казахстан руу ОХУ-ын нутаг дэвсгэрээр нэг удаа визгүй дамжин өнгөрүүлэх санал тавьж хэлэлцүүлсэн бөгөөд энэ саналаа оросын талд ноот бичгээр тавихаар тохиролцов.

Гадаад хэргийн сайд Н.Энхболд Кувейт Улсын Ерөнхий сайдын орлогч бөгөөд Гадаад хэргийн сайдын урилгаар 11 дүгээр сарын 7-8-нд Кувейт Улсад албан ёсны айлчлал хийв. Сайд Кувейтийн Гадаад хэргийн сайдтай албан ёсны хэлэлцээ хийж, Кувейтийн Ерөнхий сайд, Үндэсний Ассамблейн Дарга нарт бараалхаж, Кувейтийн сангийн Ерөнхий захиралтай уулзаж, хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцов.

Монгол Улсын Ерөнхийлөгчийг Италид айлчлуулах асуудлаар өргөмжит консул А.Коллеонитай харилцсаны дагуу Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөхөд албан бичиг илгээж, урилгыг бичгээр ирүүлэх талаар ажиллахыг А.Коллеонид хүсэлт болгов. Мөн Италийн Гадаад хэргийн яамтай харилцах чиглэлээр ажиллаж байна.

"Монгол Улсаас БНПУ-д төлөх өрийн асуудлыг зохицуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн орчуулгыг хянан баталгаажуулж, 11 дүгээр сарын 9-нд Сангийн сайд Н.Баяртсайхан, Польшийн Элчин сайд Збигнев Кулак нар гарын үсэг зурав.

НҮБ-ын Дүрвэгсдийн дээд комиссарын газрын Бүсийн төлөөлөгч Вийрапонг Вонгравотай Монгол Улсад айлчлахтай холбоотой бэлтгэл ажлын хүрээнд УИХ-ын дарга, Гадаад хэргийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх нартай уулзуулах ажлыг зохион байгуулж, Гадаад хэргийн сайд Н.Энхболд, УИХ-ын дарга Ц.Нямдорж нарын ярианы сэдвийг бэлтгэв.

Гватемал Улстай дипломат харилцаа тогтоох тухай УИХ-ын тогтоол батлуулах асуудлыг Засгийн газрын 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Асуудлыг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг ХЗДХЯ-наас хүсэв.

Саудын Арабтай дипломат харилцаа тогтоох асуудлыг Гадаад хэргийн Сайдын зөвлөл, Засгийн газар, УИХ-ын байнгын хороогоор хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулахаар ажиллав.

2006 оны 11 дүгээр сарын 1-нээс 3-ны өдрүүдэд Индонезийн Батам аралд болсон Итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх дипломат үйл ажиллагааны асуудлаарх АСЕАН-ы Бүсийн чуулга /АРФ/-ын чуулган хоорондын ажлын хэсгийн 2006-2007 оны нэгдүгээр уулзалтад оролцов.

Япон Улсын Засгийн газраас 2006 оны санхүүгийн жилд Монгол Улсад 8 тэрбум төгрөгтэй дүйцэх Төслийн бус буцалтгүй тусламж 2 тэрбум төгрөгтэй тэнцэх Хүнсний буцалтгүй тусламж олгох тухай Ноот бичгүүдэд энэ оны 11 дүгээр сарын 23-ны өдөр сайд Н.Энхболд, элчин сайд Я.Ичихаши нар гарын үсэг зурав.

Хилийн чанадад Монголын харъяатаас гарсан, нас барсан, сураггүй алга болсон, бусдад дээрэмдүүлсэн, хорих ял эдэлж байгаа болон саатуулагдсан, гэмт хэрэг үйлдсэн, эмчлүүлэхийг хүссэн, үйлдвэрлэлийн осолд орсон, гэмтсэн, хууль бусаар зорчсон, гадаадын орноос албадан буцаагдсан, бусад орны виз хүссэн зэрэг 30 иргэний асуудлыг холбогдох байгууллага, дипломат төлөөлөгчийн газарт тавьж шийдвэрлэх чиглэлээр ажиллав.

Монгол Улсын Засгийн газар Монгол дахь НҮБ-ын байгууллагуудын дэмжлэгтэйгээр 2006 оны 10 дугаар сарын 25-наас 27-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан "ДОХ-ын тархалт багатай орнуудад халдвараас урьдчилан сэргийлэх, эмчилгээ, тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох арга зам" сэдэвт бүсийн анхдугаар бага хуралд оролцов.

10 дугаар сарын 19-нд Малайзад Монголын иргэн 28 настай Шаарийбуугийн Алтантуяагийн амь насыг бүрэлгэсэн хэрэг гарсныг илрүүлэх талаар Малайзын эрх бүхий байгууллагуудтай хамтарч ажиллав. Малайзын Гадаад хэргийн сайд Датук Сери Саид Хамид Албар элчин сайд Я.Батсуурийг 11 дүгээр сарын 15-нд итгэмжлэх жуух бичгээ барьсантай нь холбогдуулан хүлээн авч уулзан Монголын иргэний амь насыг зэрлэгээр хөнөөсөн хэрэг гарсанд гүнээ харамсаж байгаагаа илэрхийлээд энэ хэргийг бүрэн илрүүлж шийдвэрлэх талаар Малайзын холбогдох байгууллагууд идэвхтэй ажиллаж байгааг мэдэгдэв. Бангкок дахь

ЭСЯ, Куала Лумпур дахь Монголын өргөмжит консулаар дамжуулан хэргийн талаар мэдээлэл авах, мөрдөн байцаах ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авч байна.

Японы “ЖАЙКА” байгууллагын сайн дурын ажилтан, Япон Улсын иргэн Кавасаки Шиний амь насыг хөнөөсөнтэй холбогдох хэргээр зохицуулалтын арга хэмжээ авч ажиллав.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1718 тоот тогтоолын дагуу Монголын далбаа бүхий хөлөг онгоцны ахмадуудад холбогдох үүрэг даалгавар өгөх ажлын баримт бичиг боловсруулав.

Хүн хил давуулан гаргах, наймаалах болон үндэстэн дамнасан бусад гэмт хэргийн талаарх Балийн үйл явцын байгууллагаас 2006 оны 11 дүгээр сарын 7-9-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Индонези Улсын Бали аралд зохион байгуулсан “Хүн наймаалах гэмт хэрэг: хохирогчдыг дэмжих нь” сэдэвт семинарт оролцов.

Дэлхийн хамгийн том хувийн нүүрсний компани болох “Пибоди Энержи” компанийн Хятад дахь салбарын Ерөнхийлөгч Марк Шрёдер 2006 оны 11 дүгээр сарын 5-9-нд Монголд ирж ажиллав. Тэрбээр Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нартай уулзаж, Таван Толгойн нүүрсний уурхайг ашиглахад оролцох, бусад нүүрсний ордуудад хөрөнгө оруулж хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлэв.

Бүгд Найрамдах Турк Улсын Анталья хотноо 2006 оны 11 дүгээр сарын 6-24-нд болсон Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Бүрэн эрхт төлөөлөгчдийн бага хурал, Женев хотноо 2006 оны 11 дүгээр сарын 9-нд болсон Дэлхийн эрүүл мэндийн Ассамблейн анхдугаар тусгай чуулганы үеэр болсон сонгууль, Нью-Йорк хотноо 11 дүгээр сарын 16-нд болсон Олон улсын хууль зүйн комиссын сонгуульд манай улсаас баримтлах байр суурийг боловсруулж шийдвэрлүүлэв.

НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллагатай хамтран боловсруулсан “Экспортын чигтэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах замаар ядуурлыг бууруулах” хөтөлбөрийн төсөл болон түүнд Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурах эрхийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулж санал боловсруулав.

6.ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Татварын өршөөлийн тухай, Био аюулгүй байдлын тухай хуулийн төсөл, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Төлбөрийн чадваргүй иргэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх хөтөлбөр”-ийг тус тус Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

“Төрийн архивын талаар авах арга хэмжээний тухай”, “Хөрөнгө гаргах тухай” /Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудыг бэлтгэн сугалбар хуудастайгаар 6 ботиор, Монгол Улсын түүхэнд холбогдох /1206-2006/ он дараалсан хуулийн эмхтгэлийг бэлтгэн 16 ботиор тус тус хэвлэн гаргах асуудлаар/ зэрэг Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлээд байна.

Гадаадын иргэн, харьяатын бүртгэл, зөвшөөрөл, визийн улсын хяналтын дүрэм батлах тухай, Байгууллагын архивын үндсэн заавар батлах тухай, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг тус тус боловсруулан визэнд гарган саналыг нэгтгэж байна.

Хот байгуулалтын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл, Экологийн хохирлын төлбөрийн тухай хуулийн төсөл, “Мөнгөн тусламж нийгмийн халамжийн тэтгэврийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, “Катарын Дохад болох тэмцээнд оролцох тамирчдын зардал гаргах тухай”, “Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт батлах тухай”, “Барилга худалдах тухай”, Олон улсын нийгмийн хамгааллын нийгэмлэгийн гишүүнчлэлийн татварын тухай” зэрэг Засгийн газрын 35 шийдвэрийн төсөлд тус тус санал өглөө.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах талаар төрөөс баримтлах бодлогыг батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд Засгийн газраас өгөх санал дүгнэлтийн төслийг тус тус боловсруулж хүргүүлэв.

Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн төсөл, Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл, ХБНГУ-ын Ханнс Зайделийн сангийн “Эрх зүй болон захиргааны салбарт дэмжлэг, туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх” төслүүдийн шинэ үе шат эхлэх гэж байгаатай холбогдуулан харьяа агентлаг, байгууллагуудын хэмжээнд төслүүдийн хүрээнд хэрэгжүүлж болох арга хэмжээнүүдийн судалгаа, хэрэгцээг тодорхойлсон. Түүнчлэн төслүүд болон донор байгууллагуудын нэгдсэн уулзалтыг зохион байгуулав.

Эрх зүйн дээд боловсролын агуулга, стандартыг шинэчлэх зорилгоор “Эрх зүйн бакалаврын боловсролын стандарт”-ыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар байгуулан ажиллаж байгаа бөгөөд уг стандартын төслийн эцсийн хувилбарыг боловсруулаад байна.

Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор бэлтгэн явуулдаг “Хуулийн цаг”, “Асуувал хариульа” телевизийн нэвтрүүлэг, “Шинэ товчоо” радио нэвтрүүлгийн ээлжит дугаарыг бэлтгэн нэвтрүүлэв.

Улс тунхагласны ойн баяр болон хууль зүйн алба байгуулагдсаны 85 жилийн ойд зориулан аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газруудтай хамтран иргэдэд зориулсан Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан хүний эрх, эрх чөлөөний талаарх мэдлэгийг иргэдэд олгох зорилготой эрх зүйн албан бус сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулав. Түүнчлэн аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга нарын ээлжит семинар, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр” үндэсний зөвлөлдөх уулзалтыг НҮБ-ын Эмэгтэйчүүдийн сантай хамтран тус тус зохион байгуулав.

Тайлангийн хугацаанд холбогдох төрийн захиргааны байгууллагуудын зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсад албан хэргээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл гадаадын 886 иргэнд олгож, 1345 хүний оршин суух зөвшөөрлийг сунгаж, нутаг буцсан 2327 хүнийг бүртгэлээс хассан байна.

Монгол Улсын харъяатаас гарах хүсэлт гаргасан казах 46 өрхийн 195 хүний холбогдох баримт бичгийг хянан Ерөнхий сайдад танилцуулж, улмаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлээд байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР